Шүүгдэгч “Праймер” ХХК нь хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө өөрийн байрлах байрандаа Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис ашиглах дүгнэлт гаргуулж, ашиглах зөвшөөрөлгүйгээр, химийн хорт болон аюултай бодисыг 2018 оны 10 дугаар сараас 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, үргэлжилсэн үйлдлээр мах, сүүний магадлан шинжилгээнд химийн бодисын хэмжээг тооцоолон гаргах түүнчлэн сүү айрагт болон бусад шингэн хүнсэнд ус хольсон эсэхийг тодорхойлох зорилгоор хууль бусаар үйл ажиллагаандаа ашиглаж, хадгалсан,

Шүүгдэгч С.Лхагвасүрэн нь өөрийн Лабораторийн оношлуур үйлдвэрлэл, худалдаа, шинжлэх ухааны туршилт судалгаа, хүнс, хөдөө аж ахуйн зөвлөх үйлчилгээ, инноваци, технологи дамжуулалт, мал эмнэлгийн үйлчилгээ мэргэшүүлэх сургалтын үйл ажиллагаа явуулдаг “Праймер” ХХК-аар дамжуулан өөрийн байрандаа Монгол Улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодис ашиглах дүгнэлт гаргуулж, ашиглах зөвшөөрөлгүйгээр, Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын сайд, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн А/356/396 дугаартай хамтарсан тушаалын 3 дугаар хавсралтын “Химийн хорт болон аюултай бодисын ангилалд хамруулсан бодисын жагсаалт”-ын 520 дугаар жагсаалт, 158 дугаарт багтсан 601 дүгээрт багтсан 3 төрлийн химийн хорт болон аюултай бодисыг 2018 оны 10 дугаар сараас 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, үргэлжилсэн үйлдлээр мах, сүүний магадлан шинжилгээнд химийн бодисын хэмжээг тооцоолон гаргах түүнчлэн сүү айрагт болон бусад шингэн хүнсэнд ус хольсон эсэхийг тодорхойлох зорилгоор хууль бусаар үйл ажиллагаандаа ашиглаж, хадгалсан гэмт хэрэгт тус тус холбогджээ.